

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА- 2024\67\НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.01.25 № 09/165  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.Т

Төв аймгийн Мөнгөнморьт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 5 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 98,2 хувиар хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж

019020322

хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>185,099,673.79</b>	<b>194,166,070.96</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	69,063,594.21	51,720,971.44
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	69,063,594.21	51,720,971.44
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	69,063,594.21	51,720,971.44
31211	Төрийн сангийн харилцах	69,063,594.21	51,720,971.44
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	115,411.92	4,774,385.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	18,664.61	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	4,774,385.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	96,747.31	00.00
3351	Байгууллагаас авах авлага	96,747.31	00.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	7,458,810.12	1,018,310.21
34600	Урьдчилж гарсан зардал	7,458,810.12	1,018,310.21
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	108,461,857.54	136,652,404.31
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	77,050,549.92	102,838,226.69
35130	Эм боох материал	77,050,549.92	102,838,226.69
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	31,411,307.62	33,814,177.62
35410	Бичиг хэргийн материал	2,898,886.00	2,895,806.00
35420	Аж ахуйн материал	25,621,419.58	28,079,619.58
35430	Сэлбэг хэрэгсэл	374,000.00	374,000.00
35440	Түлш, шатах тослох материал	02.04	02.04
35460	Хүнсний материал	1,837,000.00	1,784,750.00
35470	Бусад хангамжийн материал	680,000.00	680,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>644,517,601.01</b>	<b>636,593,939.82</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	644,517,601.01	636,593,939.82
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	636,103,601.01	628,179,939.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	478,921,795.00	478,921,795.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,900,172.80	-58,890,469.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	151,576,434.00	151,576,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-46,267,846.41	-60,168,204.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	146,143,697.90	167,936,697.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-75,408,617.51	-91,191,592.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,935,643.83	41,935,643.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,125,082.91	-20,645,861.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,128,268.61	21,085,093.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	-900,518.70	-2,379,595.88
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,414,000.00	8,414,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,414,000.00	8,414,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>829,617,274.80</b>	<b>830,760,010.78</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,000.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	10,000.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	10,000.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	10,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	10,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>829,607,274.80</b>	<b>830,760,010.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	829,607,274.80	830,760,010.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	312,003,456.19	312,003,456.19
51101	Өмч: - төрийн	312,003,456.19	312,003,456.19
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	430,755,513.73	431,908,249.71
51210	Өмнөх үеийн үр дүн	430,755,513.73	430,755,513.73
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,152,735.98
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	86,848,304.88	86,848,304.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>829,617,274.80</b>	<b>830,760,010.78</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>628,143,443.96</b>	<b>553,554,370.25</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>87,430,973.96</b>	<b>54,096,543.24</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	87,430,973.96	54,096,543.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	87,430,973.96	54,096,543.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	6,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,430,973.96	28,446,718.74
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>496,986,070.00</b>	<b>499,457,827.01</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	43,726,400.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	38,227,000.00	44,958,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,227,000.00	44,958,700.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	458,759,070.00	454,499,127.01
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	458,759,070.00	454,499,127.01
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>502,447,646.95</b>	<b>548,337,348.93</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>502,447,646.95</b>	<b>548,337,348.93</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	496,419,909.20	540,102,953.38
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	259,191,134.64	307,024,998.02
210101	Үндсэн цалин	188,246,852.15	226,836,409.53
210102	Нэмэгдэл	37,635,884.20	45,229,552.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,230,000.00	3,583,000.00
210104	Урамшуулал	29,078,398.29	31,376,035.70
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,470,940.94	39,155,705.68
210201	Тэтгэврийн даатгал	22,678,097.76	26,833,373.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,545,647.29	3,156,867.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,012,997.88	2,468,294.00
210204	Ажилгүйдлийн даатгал	472,208.89	608,833.69
210205	Эрүүл мэндийн даатгал	4,761,989.12	6,088,337.06
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,164,192.25	35,945,504.45
210301	Гэрэл, цахилгаан	3,057,792.25	4,784,585.45
210302	Түлш, халаалт	26,936,400.00	30,926,919.00
210303	Цэвэр, бохир ус	170,000.00	234,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,239,601.00	33,654,641.91
210401	Бичиг хэрэг	3,152,360.00	2,048,850.00
210402	Тээвэр, шатахуун	25,031,361.00	26,899,311.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,224,680.00	1,367,180.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000.00	1,211,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	991,200.00	2,128,100.00
2105	<b>Нормативт зардал</b>	36,412,836.33	46,543,490.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,724,175.33	34,488,632.63
210502	Хоол, хүнс	7,321,861.00	11,840,958.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	366,800.00	213,900.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,811,900.00	3,720,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	130,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	894,900.00	00.00
210604	Урсгал засвар	3,787,000.00	3,720,800.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	1,861,000.00	1,578,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,861,000.00	1,578,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	504,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	88,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	100,268,304.04	71,975,812.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,137,800.00	23,302,327.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,130,504.04	48,673,485.69
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,027,737.75	8,234,395.55
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	6,027,737.75	8,234,395.55
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	00.00	00.00
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	00.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,027,737.75	8,234,395.55
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>125,695,797.01</b>	<b>5,217,021.32</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	23,143,312.49	4,064,285.34
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	23,143,312.49	4,064,285.34
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-23,143,312.49	-4,064,285.34
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>102,552,484.52</b>	<b>1,152,735.98</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>530,406,350.00</b>	<b>500,683,442.01</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>6,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	6,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	6,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	6,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>530,406,350.00</b>	<b>494,683,442.01</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	38,227,000.00	44,958,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	38,227,000.00	44,958,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	43,726,400.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	448,452,950.00	449,724,742.01
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	448,452,950.00	449,724,742.01
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>462,342,555.69</b>	<b>496,926,064.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>462,342,555.69</b>	<b>496,926,064.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>456,314,817.94</b>	<b>488,691,669.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	259,764,110.62	306,919,746.10
210101	Үндсэн цалин	188,865,819.79	221,609,591.50
210102	Нэмэгдэл	37,616,929.06	47,312,293.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,219,997.83	3,583,000.00
210104	Урамшуулал	29,061,363.94	34,414,860.76
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,282,080.67	39,155,705.68
210201	Тэтгэврийн даатгал	23,258,273.38	26,833,373.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,578,780.22	3,156,867.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,039,384.24	2,468,294.00
210204	Ажилгүйдлийн даатгал	491,522.03	608,833.69
210205	Эрүүл мэндийн даатгал	4,914,120.80	6,088,337.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,164,192.25	35,945,504.45
210301	Гэрэл, цахилгаан	3,057,792.25	4,784,585.45
210302	Түлш, халаалт	26,936,400.00	30,926,919.00
210303	Цэвэр, бохир ус	170,000.00	234,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,891,180.00	26,715,162.00
210401	Бичиг хэрэг	3,455,300.00	2,056,850.00
210402	Тээвэр, шатахуун	27,643,800.00	20,458,812.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,302,680.00	1,308,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000.00	1,276,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	649,400.00	1,614,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	49,057,057.80	50,688,424.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,675,254.00	36,989,716.00
210502	Хоол, хүнс	10,381,803.80	11,788,708.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,910,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,679,402.60	23,720,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,905,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,634,402.60	00.00
210604	Урсгал засвар	4,140,000.00	23,720,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,861,000.00	1,578,000.00
210702	Дотоод албан томилолт	1,861,000.00	1,578,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	504,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	88,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,615,794.00	3,464,327.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,615,794.00	3,464,327.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,027,737.75</b>	<b>8,234,395.55</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	6,027,737.75	8,234,395.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,027,737.75	8,234,395.55
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>68,063,794.31</b>	<b>3,757,377.23</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>21,100,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>21,100,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	21,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	21,100,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-21,100,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	68,063,794.31	-17,342,622.77
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	999,799.90	69,063,594.21
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	69,063,594.21	51,720,971.44

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,003,456.19	87,296,162.28	-69,782,353.43	329,517,265.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	429,420.40	429,420.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,003,456.19	87,296,162.28	-69,352,933.03	329,946,685.44
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	837,540.82	837,540.82
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,003,456.19	86,848,304.88	430,755,513.73	829,607,274.80
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,003,456.19	86,848,304.88	430,755,513.73	829,607,274.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,003,456.19	86,848,304.88	430,755,513.73	829,607,274.80
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,152,735.98	1,152,735.98
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,003,456.19	86,848,304.88	431,908,249.71	830,760,010.78

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	630,449,900.00	470,566,437.78	159,883,462.22	74.6
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	630,449,900.00	470,566,437.78	159,883,462.22	74.6
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	625,449,900.00	470,566,437.78	154,883,462.22	75.2
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	403,073,100.00	306,919,746.10	96,153,353.90	76.1
210101	Үндсэн цалин	254,116,300.00	221,609,591.50	32,506,708.50	87.2
210102	Нэмэгдэл	65,827,200.00	47,312,293.84	18,514,906.16	71.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,880,800.00	3,583,000.00	297,800.00	92.3
210104	Урамшуулал	79,248,800.00	34,414,860.76	44,833,939.24	43.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,273,600.00	39,155,705.68	8,117,894.32	82.8
210201	Тэтгэврийн даатгал	32,146,600.00	26,833,373.47	5,313,226.53	83.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,780,900.00	3,156,867.46	624,032.54	83.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,025,200.00	2,468,294.00	556,906.00	81.6
210204	Ажилгүйдлийн даатгал	757,000.00	608,833.69	148,166.31	80.4
210205	Эрүүл мэндийн даатгал	7,563,900.00	6,088,337.06	1,475,562.94	80.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,654,900.00	26,715,162.00	6,939,738.00	79.4
210401	Бичиг хэрэг	2,250,000.00	2,056,850.00	193,150.00	91.4
210402	Тээвэр, шатахуун	24,964,300.00	20,458,812.00	4,505,488.00	81.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,440,000.00	1,308,600.00	131,400.00	90.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,300.00	1,276,200.00	224,100.00	85.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,300.00	1,614,700.00	1,885,600.00	46.1
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	66,473,100.00	50,688,424.00	15,784,676.00	76.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,935,100.00	36,989,716.00	12,945,384.00	74.1
210502	Хоол, хүнс	13,163,000.00	11,788,708.00	1,374,292.00	89.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,375,000.00	1,910,000.00	1,465,000.00	56.6
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	50,689,200.00	44,042,000.00	6,647,200.00	86.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000,000.00	21,100,000.00	3,900,000.00	84.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,625,300.00	00.00	2,625,300.00	
210604	Урсгал засвар	23,063,900.00	22,942,000.00	121,900.00	99.5
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,250,000.00	1,578,000.00	672,000.00	70.1
210702	Дотоод албан томилолт	2,250,000.00	1,578,000.00	672,000.00	70.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,050,000.00	504,000.00	546,000.00	48
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	216,000.00	84,000.00	72
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	88,000.00	12,000.00	88
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	450,000.00	00.00	450,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20986000.00	9634000.00	20,022,600.00	46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,986,000.00	963,400.00	20,022,600.00	46
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,000,000.00	00.00	5,000,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	00.00	5,000,000.00	0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	618,249,900.00	455,724,742.01	162,525,157.99	73.7
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	543,186,000.00	449,724,742.01	93,461,257.99	82.8
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	0.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	543,186,000.00	449,724,742.01	93,461,257.99	82.8
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	6,000,000.00	-6,000,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	6,000,000.00	-6,000,000.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	69,063,594.21	-69,063,594.21	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	51,720,971.44	-51,720,971.44	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22.00	21.00	1.00	95.4
620001	Удирдах ажилтан	00.00	01.00	-1.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	06.00	04.00	2.00	66.7
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	5,637.00	5,637.00	0.00	100
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	5,637.00	5,637.00	0.00	100

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оныг "Эх хүүхдийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 5 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 98,2 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь 21 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 95,1 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 86,9 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Мөнгөнморьт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,142.7 мянган төгрөгөөр буюу 0,1 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	69,063.6	51,721.0	17,342.6
<b>Авлага</b>			
Урьдчилгаа	7,458.8	1,018.3	-6,440.5
Бараа материал	108,461.9	136,652.4	28,190.5
Үндсэн хөрөнгө	644,517.6	636,593.9	-7,923.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>829,617.3</b>	<b>830,760.0</b>	<b>1,142.7</b>
<b>Өр төлбөр</b>			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	312,003.4	312,003.4	
Хуримтлагдсан ашиг	430,755.5	431,908.2	
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>829,617.3</b>	<b>830,760.0</b>	<b>1,142.7</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 17,342.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 28,190.5 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 79,398.1 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл боох материал, хүнсний материал, аж ахуйн бараа материал худалдан авсан.
- Хандиваар 28,446.1 мянган төгрөгийн эм эмийн хэрэгсэл, боох материал үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Бараа материал данснаас байгууллагын үйл ажиллагаанд 79,654.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 636,593.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,923.7 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэл хасагдсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад:

- 21,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр, 693.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар тус тус худалдаж авсан.
- 18,956.8 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Акталж устгасан үндсэн хөрөнгө 2023 онд дансны бичилт хийгдээгүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 543,186.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 42,305.2 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 44,958.7 мянган төгрөг нийт зарлагыг 630,449.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 630,449.9 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 630,449.9 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 449,724.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 44,958.7 мянган төгрөгийг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 6,000.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 500,683.4 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 449,724.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 44,958.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 6,272.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 507,290.7 мянган төгрөг буюу 75,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 168,117.9 мянган төгрөгөөр, үүнээс цалин нэмэгдэл, урамшуулал 96,153.3 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардлыг 7,813.2 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 6,939.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 15,784.7 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 7,068.4 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71802 Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	197,842.6	188,979.7	8,862.9	95,5%
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	6,091.9	6,091.9		100%
81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	39,237.9	38,881.4	356.5	99,1%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	13,543.7	13,275.6	37.7	98,2%
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	8,723.3	8,723.3		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71802-80101	2023-12-31	Үндсэн үйл ажиллагааны зардал	95,52%	197,842.6	188,979.7
2	71802-80215	2023-12-31	Эрдэм шинжилгээ, судалгааны зардал	100%	6,091.9	6,091.9
3	71802-81855	2023-12-31	Үр дүнд суурилсан санхүүжилт	99,09%	39,237.9	38,881.4
4	71802-80802	2023-12-31	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	98,02%	13,543.7	13,275.6
5	71802-83603	2023-12-31	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	100%	8,723.3	8,723.3

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас тендер шалгаруулсан газруудаас эм, эмийн хэрэгсэл боох материалыг нийлүүлдэг. Хүнсний бараа материалыг сумын худалдан авах ажиллагааны газрын зөвшөөрөлтэй Мөнгөнморьт сумын Баясгалант булаг ХХК-аас нийлүүлдэг байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 455,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 9,100.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,280.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 4 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 96,153.3 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 14,881.6 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 7,485.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 156 мэдээллийг байршуулж 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн газрын эхний 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн Завсрын аудитын явцад хөрөнгийн болон зардлын данстай холбоотой 3,530.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>					
<b>Албан шаардлага</b>	1	2,858.0	1	2,858.0	100
<b>Зөвлөмж</b>	3	16,184.4	3	16,184.4	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>19,042.4</b>	<b>4</b>	<b>19,042.4</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,045.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,045.0 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Хангамжийн бараа материал дансанд бүртгэгдсэн байсан 1,045.0 мянган төгрөгийн хогийн бункерийг бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 2,485.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 2,485.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Авто тээврийн хэрэгслийн хувийн хэргийн хөтлөлтийг шалгахад тухайн авто машины хувийн хэрэгт явсан км, зарцуулагдсан шатахуун, сэлбэгийг тухай бүр бүртгээгүй байна. Энэ нь Зам тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 71 тоот тушаалаар батлагдсан техник ашиглалтын хувийн хэрэг хөтлөх журмыг мөрдөж ажиллаагүй ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэсэн заалтыг зөрчсөн байна

###### Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн дагуу авто машины хувийн хэргийг хөтөлж хэвших

## 2.Зардлын данстай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

2023 оны 07 дугаар сард гадна талын банзан хашааг эвдэрснийг нь засаж янзалсан боловч засварын зардлыг гүйцэтгэлийн тайлантай тулгахад банз хадаас зэрэг 2,485.5 мянган төгрөгийн хангамжийн бараа материалын тайланд нягтлан бодогчийн гарын үсэг дутуу байсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6-д "бүх зардал" зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭ ГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хангамжийн бараа материалд бүртгэсэн хогийн бункер үндсэн хөрөнгөнд бүртгэх	1	1,045.0					1	1,045.0				
Дүн	1	1,045.0					1	1,045.0				

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөрөнгийн данстай холбоотой Авто машины хувийн хэрэг бүрэн хөтлөх	1	0					1					
Урсгал засварт зарцуулсан хангамжийн бараа материалын тайланд нягтлан бодогч гарын үсэг зураагүй	1	2,485.5					1	2,485.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,485,5</b>					<b>2</b>	<b>2,485.5</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансанд байршуулах 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1	19,042.4						1	19,042.4
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>19,042.4</b>						<b>1</b>	<b>19,042.4</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
Нийт дүн									

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)